**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/94/НА-СТА-ТЗШ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваацням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0808@gmail.com



Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
3. Аудитын тайлан ....9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....9
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин ....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....11
4. АУДИТЫН ТАЙЛАН ....12
4.1 Ерөнхий зүйл ....12
4.2 Материаллаг байдал ....12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....13
5. Аудитын илрүүлэлт ....13
5.2 Төлбөрийн акт ....14
5.3 Албан шаардлага ....14
5.4 Зөвлөмж ....14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/94
танай ______ -ны № ______ -т

ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Я.ЭРДЭНЭЖАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын жилийн нийт төсвийн 65 хувийг цалин хөлс нэмэгдэл, урамшуулал болон ажил олгогчийн НДШ-ийн зардал эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 117,723.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,393,390.42** | **45,637,040.42** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **43,393,390.42** | **45,637,040.42** |
| **354** | **Хангамжийн материал** | **43,393,390.42** | **45,637,040.42** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,008,675.00 | 811,775.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,540,690.42 | 23,084,990.42 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,099,750.00 | 1,764,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,130,000.00 | 1,412,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,614,275.00 | 18,564,275.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **419,192,868.12** | **501,484,217.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **419,192,868.12** | **501,484,217.72** |
| **392** | **Биет хөрөнгө** | **356,653,294.23** | **439,361,875.91** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 206,930,025.30 | 233,430,025.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -49,149,815.32 | -61,100,781.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 144,629,950.59 | 150,393,668.59 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -110,310,121.72 | -77,248,991.69 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 85,402,920.00 | 117,618,016.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -58,860,262.57 | -69,709,319.20 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,133,796.00 | 12,133,796.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,674,318.06 | -7,017,765.46 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 122,060,242.00 | 122,060,242.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -32,645,508.43 | -43,681,082.59 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 78,586,800.00 | 111,301,842.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -36,450,413.56 | -48,817,773.52 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **62,539,573.89** | **62,122,341.81** |
| 39301 | Програм хангамж | 1,268,750.00 | 1,268,750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -213,616.11 | -630,848.19 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 61,484,440.00 | 61,484,440.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **462,586,258.54** | **547,121,258.14** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **462,586,258.54** | **547,121,258.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **462,586,258.54** | **547,121,258.14** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 225,884,767.83 | 225,884,767.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 225,884,767.83 | 225,884,767.83 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **112,466,828.55** | **197,001,828.15** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 112,466,828.55 | 112,466,828.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 84,534,999.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 124,234,662.16 | 124,234,662.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **462,586,258.54** | **547,121,258.14** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **418,606,972.59** | **534,667,856.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **90,808,644.59** | **141,031,856.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **90,808,644.59** | **141,031,856.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 90,808,644.59 | 141,031,856.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 90,808,644.59 | 141,031,856.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **327,798,328.00** | **393,636,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,597,528.00** | **12,789,800.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,700,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 722,528.00 | 12,509,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 175,000.00 | 280,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **325,200,800.00** | **380,846,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 325,200,800.00 | 380,846,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **386,775,071.41** | **450,132,856.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **386,775,071.41** | **450,132,856.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **344,804,722.41** | **372,420,877.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **194,740,608.00** | **188,170,214.41** |
| 210101 | Үндсэн цалин | 194,740,608.00 | 156,027,125.41 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 20,104,316.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,038,773.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **25,610,273.00** | **23,746,232.80** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,151,067.00 | 16,473,268.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,947,406.00 | 1,881,701.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,557,925.00 | 1,505,361.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 359,444.00 | 353,265.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,594,431.00 | 3,532,636.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,981,773.00** | **19,131,954.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,803,663.00 | 2,620,636.58 |
| 210302 | Түлш, халаалт | 7,178,110.00 | 16,511,318.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,770,913.00** | **33,278,790.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,497,100.00 | 3,768,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,444,312.00 | 24,872,890.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,167,687.00 | 2,208,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,700,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,123,000.00 | 2,429,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 10,838,814.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **00.00** | **83,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 83,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,610,000.00** | **10,912,250.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,610,000.00 | 10,912,250.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,536,000.00** | **1,919,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,536,000.00 | 1,919,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,641,301.00** | **21,750,179.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,756,056.00 | 20,524,320.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 96,474.00 | 105,307.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 90,709.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 700,000.00 | 837,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 88,771.00 | 138,393.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **60,913,854.41** | **73,428,656.40** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,023,000.00 | 7,811,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 239,900.00 | 715,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,650,954.41 | 64,902,506.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,970,349.00** | **77,711,979.21** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **14,460,800.00** | **16,834,724.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 384,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,156,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,000.00 | 1,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **27,509,549.00** | **60,877,255.21** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,509,549.00 | 60,877,255.21 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **31,831,901.18** | **84,534,999.60** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **31,831,901.18** | **84,534,999.60** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **225,884,767.83** | **124,234,662.16** | **80,634,927.37** | **450,307,898.63** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 31,831,901.18 | -19,553,541.27 |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **225,884,767.83** | **124,234,662.16** | **112,466,828.55** | **462,586,258.54** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **225,884,767.83** | **124,234,662.16** | **112,466,828.55** | **462,586,258.54** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 84,534,999.60 | 84,534,999.60 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **225,884,767.83** | **124,234,662.16** | **197,001,828.15** | **547,121,258.14** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **162,421,328.00** | **393,636,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **162,421,328.00** | **393,636,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **422,528.00** | **12,789,800.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 422,528.00 | 12,509,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 280,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **161,998,800.00** | **380,846,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 161,998,800.00 | 380,846,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **144,105,993.00** | **387,166,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **144,105,993.00** | **387,166,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **130,449,193.00** | **309,454,020.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **95,707,263.00** | **188,170,267.53** |
| 210101 | Үндсэн цалин | 76,848,887.00 | 156,027,178.81 |
| 210102 | Нэмэгдэл | 18,858,376.00 | 20,104,315.72 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,038,773.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,998,415.00** | **23,746,179.68** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,385,106.00 | 16,455,051.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 924,576.00 | 1,932,887.93 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 739,661.00 | 1,505,990.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 175,538.00 | 350,204.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,773,534.00 | 3,502,045.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **7,999,355.00** | **14,796,204.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 516,995.00 | 2,620,636.58 |
| 210302 | Түлш, халаалт | 7,482,360.00 | 12,175,568.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,546,999.00** | **34,652,440.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 729,600.00 | 3,571,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,083,312.00 | 24,873,140.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,078,687.00 | 2,208,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 655,400.00 | 4,000,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | **00.00** | **2,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 2,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **666,600.00** | **10,495,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 666,600.00 | 10,495,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **458,000.00** | **1,919,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 458,000.00 | 1,919,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **767,661.00** | **23,821,829.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 333,416.00 | 22,595,970.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 96,474.00 | 105,307.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 90,709.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 249,000.00 | 837,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 88,771.00 | 138,393.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,304,900.00** | **9,852,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,065,000.00 | 9,137,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 239,900.00 | 715,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,656,800.00** | **77,711,979.21** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,656,800.00** | **16,834,724.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 15,434,724.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,156,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **60,877,255.21** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 60,877,255.21 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,315,335.00** | **6,470,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **18,315,335.00** | **6,470,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,315,335.00** | **6,470,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **18,315,335.00** | **6,470,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,315,335.00 | 6,470,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-6,470,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **-** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/ тэгрэгээр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 380,846,100.0 | 327,679,144.8 | 53,166,955.2 | 86.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 380,846,100.0 | 327,679,144.8 | 53,166,955.2 | 86.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 363,911,300.0 | 310,844,420.8 | 53,066,879.2 | 85.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224,639,800.0 | 188,170,267.5 | 36,469,532.5 | 83.8 |
| 210101 | Үндсэн цалин | 178,338,300.0 | 156,027,178.8 | 22,311,121.2 | 87.5 |
| 210102 | Нэмэгдэл | 29,801,500.0 | 20,104,315.7 | 9,697,184.3 | |
| 210104 | Урамшуулал | 16,500,000.0 | 12,038,773.0 | 4,461,227.0 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,306,600.0 | 23,746,179.7 | 5,560,420.3 | 81.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,394,800.0 | 16,455,051.2 | 3,939,748.8 | 80.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,228,000.0 | 1,932,887.9 | 295,112.1 | 86.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,782,400.0 | 1,505,990.5 | 276,409.5 | 84.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 445,500.0 | 350,204.4 | 95,295.6 | 78.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,455,900.0 | 3,502,045.6 | 953,854.4 | 78.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,800,000.0 | 14,796,204.6 | 3,795.4 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,300,000.0 | 2,620,636.6 | 679,363.4 | 79.4 |
| 210302 | Түлш, халаалт | 11,500,000.0 | 12,175,568.0 | -675,568.0 | 105.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,420,100.0 | 33,208,840.0 | 211,260.0 | 99.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,300,000.0 | 3,291,300.0 | 8,700.0 | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,742,100.0 | 23,739,540.0 | 2,560.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,178,000.0 | 2,178,000.0 | 00.0 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.0 | 00.0 | 200,000.0 | -100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,000,000.0 | 4,000,000.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,000,000.0 | 2,000,000.0 | 00.0 | 00.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.0 | 2,000,000.0 | 00.0 | 00.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,000,000.0 | 16,965,500.0 | 34,500.0 | 99.8 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,500,000.0 | 6,470,000.0 | 30,000.0 | -00.5 |
| 210604 | Урсгал засвар | 10,500,000.0 | 10,495,500.0 | 4,500.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,000,000.0 | 1,919,600.0 | 1,080,400.0 | 64.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,000,000.0 | 1,919,600.0 | 1,080,400.0 | 64.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,984,800.0 | 22,085,829.0 | 8,898,971.0 | 71.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,334,800.0 | 20,859,970.0 | 8,474,830.0 | 71.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.0 | 54,450.0 | 65,550.0 | 45.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.0 | 105,307.0 | 144,693.0 | 42.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.0 | 90,709.0 | 41,291.0 | 68.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.0 | 837,000.0 | 163,000.0 | 83.7 |
| 210807 | Газрын төлбөр | 148,000.0 | 138,393.0 | 9,607.0 | -06.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,760,000.0 | 7,952,000.0 | 808,000.0 | 90.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,000,000.0 | 7,237,000.0 | 763,000.0 | 90.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 760,000.0 | 715,000.0 | 45,000.0 | 94.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,934,800.0 | 16,834,724.0 | 100,076.0 | 99.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,934,600.0 | 16,834,724.0 | 100,076.0 | 99.4 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,434,800.0 | 15,434,724.0 | 76.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.0 | 1,400,000.0 | 100,000.0 | 93.3 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 380,846,100.0 | 327,679,144.8 | 53,166,955.2 | 86.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 380,846,100.0 | 327,679,144.8 | 53,166,955.2 | 86.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 380,846,100.0 | 327,679,144.8 | 53,166,955.2 | 86.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 21.00 | 01.00 | 95.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 05.00 | 05.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 10.00 | 01.00 | 90.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 00.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,789,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,789,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,079,600.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,443,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 280,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,133,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,736,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,736,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,900,000.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 7,710,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,789,800.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,789,800.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,509,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 280,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар нь иргэдийн итгэл хүлээсэн төрийн үйлчилгээний манлайлагч байх, зөв оновчтой бодлого үйл ажиллагааг өрнүүлж иргэдээ дэмжүүлэн шийдвэрлэж сумаа хөгжүүлнэ гэсэн эрхэм зорилго тавин ажилласан байна.

Цагааннуур сум нь 2022 оныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох жил болгон зарласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд байгууллагын дотоод хяналтын зөвлөл 9 ажлыг хийхээр төлөвлөн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, хяналтыг хэрэгжүүлж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/375 тушаалаар баталж мөрдсөн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,903.4 мянган төгрөгөөр буюу 18 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 43,393.4 | 45,637.0 | 2,243.7 |
| Биет хөрөнгө | 356,653.3 | 439,730.3 | 83,077.0 |
| Биет бус хөрөнгө | 62,539.6 | 62,122.3 | -417.2 |
| **Нийт хөрөнгө** | 462,586.3 | 547,489.7 | 84,903.4 |
| Хуримтлагдсан үр дүн | 112,466.8 | 197,370.3 | 84,903.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 462,586.3 | 547,489.7 | 84,903.4 |

Бараа материал данс өмнөх оноос 2,243.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ой хээрийн гал түймэр гарсны улмаас авсан аж ахуйн материалуудыг орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансанд дараах хөдөлгөөнүүд хийгдсэн байна.

- Төсвийн хөрөнгөөр 6,470.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр галын машин 49,500.0 мянган төгрөг, камержуулалт 5,456.0 мянган төгрөг, цаг уурын ажиглагчийн байр 6,500.0 мянган төгрөг, дэнжийн эрчим хүчний өргөтгөл 25,215.0 мянган төгрөг, Хармайн хашаа

7,500.0 мянган төгрөг нийт 91,171.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан.

- Аймгийн хөрөнгө оруулалтаар 26,552.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
- 50,000.0 мянган төгрөгийн тракторыг дуудлага худалдан борлуулсан.

Хуримтлагдсан үр дүн 84,903.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 380,523.5 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 21,826.6 мянган төгрөгөөр бууруулж, 358,796.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 22,049.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 380,846.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 327,679.1 мянган төгрөг буюу 86 хувьтай байгаа ба 53,167.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70106** | **Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага** | **374,969.90** | **323,389.07** | **51,580.83** | **86.24** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 270,426.20 | 235,019.45 | 35,406.75 | 86.91 |
| 80106 | Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 24,992.10 | 23,575.64 | 1,416.46 | 94.33 |
| 80112 | Нийтлэг үйлчилгээ | 43,116.80 | 35,750.75 | 7,366.05 | 82.92 |
| 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 500.00 | - | 500.00 | - |
| 80305 | Биеийн тамирын уралдаан, тэмцээн | 1,000.00 | 550.00 | 450.00 | 55.00 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1,500.00 | 1,400.00 | 100.00 | 93.33 |
| 80815 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор | 15,434.80 | 15,434.72 | 0.08 | 100.00 |
| 82801 | Улсын их баяр наадам | 3,000.00 | 2,987.00 | 13.00 | 99.57 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 15,000.00 | 8,671.50 | 6,328.50 | 57.81 |
| **71413** | **Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх** | **5,876.20** | **4,290.07** | 1,586.13 | **73.01** |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 5,876.20 | 4,290.07 | 1,586.13 | 73.01 |
| | НИЙТ | **380,846.10** | **327,679.14** | **53,166.96** | **86.04** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд:

- Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 2,899.6 мянган төгрөг
- Биеийн тамир спортын газраас нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны зардалд 1,500.0 мянган төгрөг
- Цахим тендерийн орлого 280.0 мянган төгрөг
- Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардал 300.0 мянган төгрөг
- ХХҮГ-аас урамшуулалд 100.0 мянган төгрөг
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гал түймрийн зардалд 7,710.2 мянган төгрөг

Нийт 12,789.8 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зохих журмын дагуу эрхийг нээлгэж, зарцуулалтыг хийсэн ба 7,710.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны 12 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 386,775.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өгсөн албан шаардлага болон хэмнэлтийн горимыг баримталж ажиллах тухай хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 1,400.0 | 1 | 1,400.0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **1,400.0** | **2** | **1,400.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 668.5 мянган зөрчил илэрч 2 зөвлөмж хүргүүллээ.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Төсвийн зарцуулалттай холбоотой***

1.1. *Илрүүлэлт:*

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 181.5 мянган төгрөгийн интернетийн төлбөр төлсөн нь Сангийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан Зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар"тай нийцэхгүй байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой***

2.1. *Илрүүлэлт:*

Баяр наадмын зардалд зарцуулсан 530.0 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтын бүрдэл дутуу /харилцагч байгууллагын зарлагын баримт, орлогын баримт/ байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байна.

2.2. *Өгсөн зөвлөмж:*

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэл тусгаж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 138.5 | | | | | 1 | 138.5 | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу | 1 | 530.0 | | | | | 1 | 530.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 2 | 668.5 | | | | | 2 | 668.5 | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 11/14

АХЛАХ АУДИТОР Б.ДАВААНЯМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: 11/15